

**Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний үеийн дэг журам,
аюулгүй байдлыг хангах ажиллагаа, түүний удирдлага зохион байгуулалт**

ХСИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн ахлахбагш,
цагдаагийн дэд хурандаа Э.Рэгдэндагва

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталснаар хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд “Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах тухай” Улсын Бага Хурлын 1992 оны 14 дүгээр тогтоолын дагуу төрийн байгууллагын шинэтгэлийг хийх ажлын хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын шинэчлэл эхэлсэн билээ.

Улмаар 1998 онд Улсын Их Хурал эрх зүйн бодлогын цаашдын чиг хандлагыг тодорхойлсон “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталж, Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчныг бүрдүүлснийг тэмдэгдэх нь зүйтэй юм.

Тус хөтөлбөрт: “Эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхдээ төрт ёсныхоо олон зуун жилийн дэвшилт уламжлал, эрх зүйн тогтолцоо бүрэлдэн бий болсон арга, хэлбэрийг харгалзан, дэлхийн улс орнуудын нийтлэг чиг хандлага, өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал, үндэснийхээ ашиг сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлана” хэмээн заажээ.

Энэхүү ажлын хүрээнд Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээлгэсэн үндсэн чиг үүргээ биелүүлэхдээ Улсын Их Хурлаас баталсан Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн гэж заасан байна.¹

Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг нь хүмүүсийн улс төр, бие бялдар, оюуны хэрэгцээг хангах зорилготой тэдгээрийн эрх ашигт нийцсэн олон түмний оролцоотойгоор явагдаж байгаа иргэдийн хүний эрх, эрх чөлөө хэрэгжих, өөр хоорондоо харилцах хэлбэр бие хүн, хамт олон, нийгэм бүхэлдээ үзэл бодол, үйл хөдлөл чиглэлээ нэгтгэх арга хэрэгсэл болсон зохион байгуулалттай үйлдлийн нийлбэр юм гэжээ.²

Нийтийг хамарсан арга хэмжээ явагдаж байгаа газарт амгалан тайван байдал бүрдүүлэх зорилгоор удирдлагын тусгай штаб байгуулах, эрх зүйн хэм хэмжээний акт гаргах, хамгаалалтын хүч нэмэгдүүлэх замаар иж бүрэн шинжтэй арга хэмжээ авч, тодорхой дэг журам тогтоон хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төр, олон нийтийн байгууллагын гүйцэтгэх захирамжлах, удирдан зохион байгуулах бүтээлч ажиллагаа мөн³ гэж доктор профессор, цагдаагийн хурандаа Д.Таванжин өөрийн бүтээлдээ тусгажээ.

Цагдаагийн байгууллага нь биеийн тамир, спортын болон бусад нийтийг хамарсан арга хэмжээ болох үед гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор өөрийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтаа түүнд уялдуулан хэв журмын хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Хэв журмын хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна.⁴ Үүнд:

1. Олон нийтийн арга хэмжээний үеийн /улсын баяр наадам, түүнтэй адилтгах олон улс, бүсийн чанартай арга хэмжээ, тэмцээн уралдаан г.м/
2. Төрийн тусгай хамгаалалтын болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үеийн

¹Цагдаагийн албаны тухай хуулийн 1-р зүйлийн 3-р бүлгийн 3.1 дэх заалт

²Д. Таванжин “ Монгол улсын Цагдаагийн эрх зүй “ УБ хот 2006 он

³Д.Таванжин “ Монгол улсын Цагдаагийн эрх зүй “ УБ хот 2006 он

⁴Нийгмийн хэв журам хамгаалах журам ЦБҮАЖ-код-400 400.5.1 дэх хэсэг

3. Хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн үеийн /жагсаал, цуглааны үеийн, нийтийн хамарсан эмх замбараагүй байдлын үеийн, гамшгийн үеийн, онц байдал тогтоосон үеийн/ гэж тус тус ялгамжтай байдлаар зааглан төрөлжүүлсэн байна.

Олон нийтийг хамарсан арга хэмжээний үед цагдаагийн байгууллагаас зохион байгуулан явуулах арга хэмжээг удирдахаар шуурхай удирдлагын штаб байгуулагдах бөгөөд түүнд зохион байгуулах, нөхцөл байдлыг үнэлэх, харилцан ажиллагааг хангах бүлгүүд багтана.

Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтыг Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон “Шуурхай удирдлагын штаб” удирдаж, хяналт тавина. Уг штабын ажиллах чиг үүргийг Цагдаагийн төв байгууллагын дарга батална гэж тусгайлан заажээ.⁵

Штаб нь тусгайлан бэлтгэсэн удирдлагын байранд байрлаж, хамгаалалтыг батлагдсан төлөвлөгөө, зураглалыг үндэслэн тухайн нөхцөл байдалд тохируулан удирдаж, шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнтэйгөөр үүрэг гүйцэтгэнэ. Штаб нь суурин болон зөөврийн радио станц, дүрс бичлэгийн камер, зургийн аппарат, сүлжээнд холбогдсон телефон утас, чанга яригч, зурагт, дуран, гэрэлтүүлэгч хэрэгсэл, цахилгаан үүсгүүр, бусад шаардлагатай техник хэрэгслээр хангагдсан байна.

Штабын байранд хууль тогтоомж, журам, заавар, тушаалын эмхтгэл, бэлэн байдлын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд, зураглал, газрын зураг, хүч, хэрэгслийн тоо, нөөцийн мэдээ, шаардлагатай алба хаагчдын холбоо барих утасны жагсаалт, радио холбооны дуудлага зэргийг бэлэн байлгана.

Мөн штабын дэргэд ажлын хэсэг ажиллаж, дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, хамгаалалтад ажиллаж байгаа анги, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан мэдээ, мэдээллийг цаг, минутаар баримтжуулах, зураглал үйлдэх, бичиг баримт төлөвлөх зэрэг удирдлагаас өгсөн бусад үүргийг гүйцэтгэнэ.

Өөрөөр хэлбэл “Шуурхай удирдлагын штаб”-ын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй, найдвартай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байхаар холбогдох эрх зүйн актанд тусгаж өгсөн байна.

Хамгаалалтын үед өгөгдөх үүргийн нууцлалыг хангах зорилгоор тусгайлан томъёолсон код, биет болон гэрлэн дохиог Цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно. Энэ нь холбоо тасрах бусад зайлшгүй шаардлагатай нөхцөлд хамгаалалтад оролцож байгаа алба хаагчид албаны тусгай зориулалтын томъёолсон код, биет болон гэрлэн дохиог ашиглан үйл ажиллагаагаа явуулахыг хэлнэ.

Нийтийг хамарсан арга хэмжээ тухайн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нийтийн эмх замбараагүй байдал болон өөрчлөгдөж болно. Тиймээс хаана, хэдийд, ямар зорилго, чиглэлтэй нийтийн эмх замбараагүй байдал үүсч болзошгүйг судлан Цагдаагийн байгууллагаас ажиллах шуурхай төлөвлөгөөнүүдийг хэд хэдэн хувилбараар боловсруулж байнгын бэлтгэлтэй байх нь чухал ач холбогдолтой юм.

Төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгасан байвал зохино.

- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч болзошгүй газар, түүний онцлог
- Бие бүрэлдэхүүнээ бэлэн байдал зарлаж богино хугацаанд цуглуулах талаар
- Бие бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь
- Бие бүрэлдэхүүний зэвсэг, тусгай хэрэгслийн талаар
- Тухайн нөхцөлд ажиллах томилгоот бүлэг, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг
- Тухайн газрын ойролцоо байгаа улсын онц чухал объектуудыг хамгаалах
- Замын хөдөлгөөнийг хаах, чиглэлийг нь өөрчлөх талаар
- Хууль бус үйл ажиллагаанд өртөж болзошгүй иргэдийн аюулгүй байдлыг хангах
- Нийтийн үйлчилгээний газрын үйл ажиллагааг түр зогсоох, хаах
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах
- Онцгой байдал, тагнуул, прокурор, эмнэлэг, гэрээт харуул хамгаалалт, төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах
- Цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангах
- Гарч болох хохирлыг тооцсон байх

Шуурхай удирдлагын штаб нь дараах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

- Бие бүрэлдэхүүнд зааварчилгаа өгч, бүлгийн удирдагчид зорилгыг нь тодорхойлж өгөх

⁵Нийгмийн хэв журам хамгаалах журам ЦБҮАЖ-код-400 400.6.1 дэх хэсэг

- Дээд шатны удирдлага, прокурорт мэдэгдэх
 - Цагдаагийн байгууллагын байр, улсын онц чухал объектуудыг хамгаалалтанд авах
 - Цагдаагийн алба хаагчдыг зэвсэг, тусгай хэрэгслээр хангаж ямар тохиолдолд хэрэглэх талаар зааварчлага өгөх
 - Зохион байгуулагч этгээдтэй ярилцах, хэв журам зөрчихгүй байх талаар иргэдэд зөвлөх, хүсэлт тавих
 - Бусдыг буруу үйлдэлд уруу татаж болзошгүй хүмүүс, өдөөн хатгагчдыг илрүүлж тусгаарлах
 - Эмх замбараагүй байдалд оролцогчдын хууль бус үйл ажиллагааг баримтжуулж бэхжүүлэх
 - Оролцогчид дотор галт зэвсгээр зэвсэглэсэн байж болзошгүй хүмүүсийг хянах, ажиглалт хийх
 - Эмх замбараагүй байдал гарсан газрын эргэн тойронд хааж бүслэх
 - Эмх замбараагүй байдал эрчимжиж газар авсан тохиолдолд нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, усан хөөрөг, утаат хөшиг, үүсгэгч зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг заавар, журмын дагуу хэрэглэх
 - Нийтийн эмх замбараагүй байдалд нэрвэгдсэн, хүч хэрэглэсний улмаас хохирсон иргэдэд туслалцаа үзүүлж, өмч хөрөнгийг хамгаалтад авах
- Нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед тусгайлсан чиг үүрэгтэй дараах бүлгүүд

ажиллахаар тусгасан байна.⁶ Үүнд:

- Тандан судлах бүлэг
- Хэлэлцээр хийх бүлэг
- Бүслэн хаах бүлэг
- Эргүүлийн бүлэг
- Шалган нэвтрүүлэх бүлэг
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүлэг
- Татан гаргаж, салган тусгаарлах бүлэг:
- Тусгай хэрэгсэл хэрэглэх бүлэг
- Дайчлан баривчлах бүлэг
- Хуяглан хүргэх бүлэг
- Баримтжуулах бүлэг
- Мөрдөн шалгах бүлэг
- Хэвлэл мэдээллийн бүлэг
- Холбооны бүлэг
- Эмнэлгийн тусламжийн бүлэг
- Хяналт, шалгалтын бүлэг
- Санхүү хангалтын бүлэг
- Нөөц бүлэг гэж төрөлжүүлэн ангилж өгсөн байна.

Бүлгүүд нь нийтийн эмх замбараагүй байдлын үед дор дурдсан байдлаар хамтарч ажиллавал зохино. Үүнд:

- Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн үед тусгайлсан чиг үүрэгтэй бүлгүүд бие биенийнхээ аюулгүй байдлыг хангаж халдлагад өртсөн цагдаагийн алба хаагчдыг аврах, хамгаалах, эмнэлэгийн байгууллагад хүргэх
- Замын хөдөлгөөн зохицуулж буй замын цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдлыг эргүүлийн цагдаагийн алба хаагчдаар хүч нэмэгдүүлэн хамгаалах
- Нөхцөл байдал хүндэрсэн үед баривчлах, тусгай хэрэгсэл ашиглах, ухуулга сурталчилгаа хэлэлцээр хийх бүлгийн алба хаагчдын нийтийн эмх замбараагүй байдлын голомтоос бусад бүлэг нөөц хүчний тусламжтайгаар аюулгүй байдлыг нь ханган яаралтай гаргах
- Хууль бус үйлдлийг баримтжуулан бэхжүүлэх үүрэг бүхий алба хаагчид баримтжуулсан материал, гэрэл зураг, дүрс бичлэгээ мөрдөн байцаах ажилтнуудад гарган өгч шаардлагатай этгээдүүдийг баривчлах бүлгээр баривчлуулан саатуулж хүргүүлэх

⁶Нийгмийн хэв журам хамгаалах журам ЦБҮАЖ-код-400 400.14.4 дэх хэсэг

- Цагдаагийн хэвлэл мэдээллийн алба нийтийн эмх замбараагүй байдал, зохион байгуулагчдын хууль тогтоомж зөрчиж байгаа талаар олон нийтэд тогтмол мэдээлэх
- Баривчлан саатуулсан этгээдүүдийг мөрдөн байцаах, тусгаарлах, байрны харуул хамгаалалтыг сайжруулах, хуяглан хүргэхэд туслах

Шуурхай удирдлагын штаб нь бүлэг болгонтой тогтмол холбоо барьж мэдээлэл цуглуулан үнэлэлт дүгнэлт өгч ямар ч тохиолдолд довтлох, тусгаарлах, баривчлах, албаны тусгай хэрэгсэл ашиглах талаар тухай бүр үүрэг, чиглэл өгч ажлын уялдааг хангаж ажилладаг байна.

Нийтийг хамарсан тусгай арга хэмжээний үеийн дэг журам, аюулгүй байдлыг хангах түүний удирдлага, зохион байгуулалтыг хийхдээ Их Британи улсын цагдаагийн байгууллага нь дараах үндсэн журмыг баримтлан ажилладаг байна.⁷ Үүнд:

1. Үнэлгээ өгөх үүргийг туршлага мэдлэгтэй мэргэжлийн хүнд даалгах. Жижиг хэмжээний арга хэмжээний үед зөвхөн нэг хүнийг томилоход болно. Том цар хүрээтэй арга хэмжээний үед удирдлагын багаас дэд хороодод өөрсдийн хариуцсан чиглэлээр судалгаа үнэлгээ хийх даалгавар, үүрэг өгч болох юм. Үнэлгээний илтгэлийг ирүүлэх цаг хугацааг тодорхой зааж өгнө.

2. Байгаа мэдээллийг цуглуулан судалгаа шинжилгээ хийх. Үүнд барилга байгууламжийн бүтцийн дотоод зураг, диаграм, нийтийн аж ахуйн байршлын зураг, цахилгаан хангамж, газар зүйн байршилын фото зураг /газрын зураг, агаараас авсан зураг/, өмнөх арга хэмжээний тайлан илтгэл, арга хэмжээ зохион байгуулагчдын зүгээс засаг захиргааныхантай байгуулсан гэрээ, контракт, хийгдсэн даатгал, барилга, байгууламжинд хийсэн шалгалтын тайлан /гал, эрүүл мэнд, аюулгүй байдал/, барилгаас хүмүүсийг шуурхай гаргах, аваарын төлөвлөгөө, байгууллага, арга хэмжээний бодлого, журам, заавар, өмч хөрөнгийн жагсаалт, үнэ өртөг гэх мэт.

3. Гол арга хэмжээ болох газруудын, зочид буудлын аюулгүй байдлын төлөвлөгөөнд үнэлгээ өгөх. Зочид буудлын аюулгүйн албаныхнаас төлөвлөгөөний талаар лавлагаа авах.

4. Тухайн газар, орчинд нарийн ажиглалт, судалгаа хийх. Хамгаалалтанд авах, аюулгүй байдлыг нь хангах бүхий л газрууд, замын хөдөлгөөний чиглэлүүд, барилга байгууламж, газар нутаг, машины зогсоол гэх мэт зүйлийг тодорхойлох. Өдрийн янз бүрийн цаг үед /гэгээтэй, харанхуй байхад/, долоон хоногийн төрөл бүрийн гаригуудад замын хөдөлгөөн ба явган зорчигчдын урсгал хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглах. Уг арга хэмжээ замын хөдөлгөөн ба явган зорчигчдийн ердийн урсгал, хэт ачаалалтай үед болон машины зогсоол зэрэг бусад зүйлд хэрхэн нөлөө үзүүлж болох. Эмзэг, бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлох. Жишээ нь: Техникийн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийнхэн иж бүрэн журам заавар боловсруулан гаргаж бөмбөг тэсрэхэд энэ нь орчны бүтэц болон хүмүүст хэрхэн нөлөөлөхийг тодорхойлсон байна.

5. Арга хэмжээнд оролцох хүмүүс тухайн газарт явж хүрэх бүхий л төрлийн тээврийн хэрэгслийг шалгах /онгоцны буудал, галт тэрэг, автобус, метро г.м./

6. Удирдах эрх бүхий байгууллагад байгаа арга хэмжээг төлөвлөж, түүнийг сурталчилж байгаа гол хүмүүстэй ярилцлага, уулзалт зохион байгуулах.

7. Гүйцэтгэх албаныхнаас аюул заналхийллийн судалгааны мэдээллийг авах.

8. Оролцогчдын талаарх нарийвчилсан судалгаа хийх. Өндөр хэргэм зэрэгтэй хүмүүс, өндөр хэмжээний зочид, арга хэмжээ зохион байгуулагчид, төрийн албан тушаалтнууд, урлагийнхан, үзэгчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн, эсэргүйцэгчид гэх мэт бүх төрлийн оролцогчдыг тодорхойлох.

9. Аюулгүй байдлын асуудалд хамааралтай байж болох оролцогчдын үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол зэрэг асуудлуудыг тодруулах.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний болон бусад арга хэмжээний үеийн дэг журам, аюулгүй байдлыг хангаж ажиллахдаа бусад байгууллагатай хамтарч ажиллах шаардлага зүй ёсоор тулгаран гардаг. Тухайлбал: Тагнуул, Онцгой байдал, Төрийн тусгай хамгаалалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөхий газар, Эмнэлэг, Засаг дарга, Төрийн захиргааны байгууллага гэх мэт

⁷Олон нийтийг хамарсан жагсаал, цуглааныг зохицуулах цагдаагийн менежмент сургалт 2014 он

Иймд эдгээр чиг үүрэг бүхий байгууллагатай хамтарсан сургалтыг зохион байгуулж албаны уялдаа холбоог хангаж ажилласнаар байгууллага хоорондын ялангуяа удирдлага зохион байгуулалтын хүрээнд тогтсон нэг аргачлалтай болох үр дүнтэй алхам болох юм.